



НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

Захиргааны хэм хэмжээний
актын улсын нэгдсэн бүртгэлд
2024 оны 01 сарын 30-ны
өдрийн 6572 дугаарт бүртгэв.

2023 оны 12 сарын 04 өдөр

Дугаар 08

Улаанбаатар хот

Тэтгэмжийн хэмжээ тогтоох тухай

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсэгт заасныг үндэслэн ТОГТООХ нь:

1. Нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмжийн хэмжээг 2 000 000 /хоёр сая/ төгрөгөөр тогтоосугай.
2. Амьгүй донор болж эс, эд, эрхтнээ бусдад шилжүүлсэн даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмжийн хэмжээг 3 500 000 /гурван сая таван зуун мянга/ төгрөгөөр тогтоосугай.
3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн ажлын алба /Г.Банзрагч/-нд үүрэг болгосугай.
4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн "Оршуулгын тэтгэмжийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 2022 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн 04 дүгээр тогтоолыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцсугай.
5. Энэ тогтоолыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.

ДАРГА



Х.БУЛГАНТУЯА